

**АӨСҮТ-ИЙН 2024 ОНЫ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хариуцах эзэн
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	❖ Байгууллагын эрхэм зорилго - олон улсын түвшинд хүрсэн арьс-харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээг чанартай шуурхай үзүүлэх ❖ Эрхэмлэх үнэт зүйлс: - Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж - Бидний итгэл, найдвар - Үйлчлүүлэгчийн арьсны эрүүл мэнд - Бидний чанарын баталгаа - Үйлчлүүлэгчийн эдгэрэлт – Бидний дэвшил, хөгжил - Үйлчлүүлэгчийн инээмсэглэл - Бидний ёс зүй, хариуцлага ❖ Бидний эрхэмлэх зарчим - Зөв хандлага, хүндлэлд суурилсан соёлтой - Үйл явц нь хэрэгцээнд суурилсан, оновчтой - Гүйцэтгэл нь үр дүнтэй, үр ашигтай - Тусламж, үйлчилгээ нь аюулгүй, чанартай - Хүний нөөц чадварлаг, мэдрэмжтэй - Хагас бие даасан тогтолцоотой СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ, ЗОРИЛГО, ЗОРИЛТ СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 1. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ Стратегийн зорилго 1. Үйлчлүүлэгчдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх Стратегийн зорилт 1.1.1. Үйлчлүүлэгчдэд арьс харшлын өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх Стратегийн зорилт 1.1.2 Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээний үр дүнг сайжруулах СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ	

		Стратегийн зорилго 2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх Стратегийн зорилт 2.1.1. Арьс харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх Стратегийн зорилт 2.1.2 Хүлээн авах, яаралтай тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, бүтэц, тусламж, үйлчилгээг сайжруулах Стратегийн зорилт 2.1.3. Чанарын удирдлагын тогтолцоо, арга хэрэгслийг сайжруулан, тасралтгүй байдлыг хангах Стратегийн зорилт 2.1.4. Арьсны өвчний сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, сувилгаа, асаргааны үр дүнг дээшлүүлэх Стратегийн зорилт 2.1.5. Эмнэлгийн халдвар, хамгаалал, ариутгалын аюулгүй байдлыг хангах Стратегийн зорилт 2.1.6. <i>Аюулгүй, эрсдэлгүй тусламж, үйлчилгээг үзүүлэх</i> Стратегийн зорилт 2.1.7. <i>Үйлчлүүлэгчид, ажилчдын аюулгүй байдлыг хангаж, дэмжлэгт орчныг бүрдүүлэх</i> СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 3. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ Стратегийн зорилго 3.1.Тасралтгүй суралцагч байгууллага байж, зөв хандлагад суурилсан хүний нөөцийг хөгжүүлэх Стратегийн зорилт 3. 1.1. Арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр чадварлаг мэргэшсэн хүний нөөцөөр хангах Стратегийн зорилт: 3.2.1. Хүний нөөцийн байршил, хангамжийг оновчтой болгож, бие даасан байдлыг хангах Стратегийн зорилт: 3.1.3. <i>Эрдэм судлал, судалгаа-шинжилгээг хөгжүүлэх</i> Стратегийн зорилт 3.1.4. Гүйцэтгэлийн удирдлагын оновчтой тогтолцоог нэвтрүүлэх Стратегийн зорилт 3.1.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны соёл, хариуцлагыг дээшлүүлэх Стратегийн зорилт 3.1.6. Хүний нөөцийн нийгмийн баталгааг сайжруулах СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 4. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТ Стратегийн зорилго 4.1 Тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлтэй нягт уялдуулан, санхүүжилтийн тогтолцоог шинэчлэн, үр ашгийг дээшлүүлэх Стратегийн зорилт 4.1.1. Эдийн засгийн үр ашиг, өртгийн тооцоолол хийж,	
--	--	--	--

		санхүүгийн удирдлагыг оновчтой болгох СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ Стратегийн зорилго. 5.1. Дэвшилтэт технологийн нэвтрэлтийг хангаж, тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулан, хүрээг өргөтгөх Стратегийн зорилт 5.1.1. Хүн амын арьсны эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлэх Стратегийн зорилт 5.1.2. Дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангаж, засвар үйлчилгээний тасралтгүй байдлыг сайжруулах СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 6. ЭМ ЗҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ Стратегийн зорилго 6.1. Эм зүйн үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг ханган, зохистой хэрэглээг төлөвшүүлэх Стратегийн зорилт 6.1.1. Клиникийн эм зүйн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх Стратегийн зорилт 6.1.2. Арьс харшил, эмчилгээний гоо заслын эм, био бэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 7: МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН УДИРДЛАГА Стратегийн зорилго 7.1. Мэдээллийн технологийн нэвтрэлтийг хангаж, цахим эмнэлэг болох Стратегийн зорилт 7.1.1. Цахим технологийг нэвтрүүлэн, цахим эмнэлэг болох СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 8. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА Стратегийн зорилго 8.1 Байгууллагын хөгжил, удирдлага зохион байгуулалт, ил тод байдлыг хангах Стратегийн зорилт 8.1.1. Хагас бие даасан засаглалыг хөгжүүлэх Стратегийн зорилт 8.1.2. Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэн, ил тод байдлыг хангах Стратегийн зорилт 8.1.3. Хэрэглэгч төвтэй, сэтгэлд шингэсэн, үйлчилгээ үзүүлэх	
--	--	--	--

		Стратегийн зорилт 8.1.4. Төрөлжсөн мэргэшлээр Улсын хэмжээнд лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэн мэргэжил арга зүйгээр хангаж, арьс харшил, эмчилгээний гоо заслын мэргэжилтэн бэлтгэх Стратегийн зорилт 8.1.5. Төр хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэн, гадаад харилцааг хөгжүүлэх Олон улсын түвшинд хүрсэн арьс-харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээг чанартай, аюулгүй, шуурхай үзүүлэх эрхэм зорилгын хүрээнд 2013 онд олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2008, MNS.ISO 9001:2010 стандартыг салбартаа анхдагчаар нэвтрүүлж, 2018, 2022 онуудад амжилтаа бататган ISO9001:2015, MNS.ISO 9001:2016 стандартыг хэрэгжилтийг ханган ажилладаг. 2020-2024 онд хэрэгжүүлэх хөгжлийн стратеги төлөвлөгөө нь 8 үндсэн чиглэлийн хүрээнд шинэ дэвшилтэд технологийг нэвтрүүлэн, арьс-харшил, эмчилгээний гоо заслын оношилгоо, эмчилгээг чанарын өндөр түвшинд хүргэхийг зорьж ажиллаж байна. 2024 оны байгууллагын хөгжлийн бодлого төлөвлөлтийг 7 зорилтын хүрээнд нийт 42 ажил төлөвлөснөөс хэрэгжилт 94.7 хувьтай байна. Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийн хэрэгжилтийн тайланг ЭМС-ын 2022 оны А/346 тоот тушаалын дагуу хугацаанд нь ЭМЯ-руу хүргүүлсэн Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилгын хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр дүнг https://derma.gov.mn/ цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулдаг. АӨСҮТ нь улсын хэмжээнд арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна. Амбулаторт арьс, харшлын, эмчилгээний гоо засал, арьсны мэс засал, өдрийн эмчилгээ, дүрс оношлогооны нийт 14 кабинет, хэвтэн эмчлүүлэх насанд хүрэгчдийн, хүүхдийн, эрчимт эмчилгээ яаралтай тусламжийн тасгууд тусламж үйлчилгээг үзүүлж ажиллаж байна.	
--	--	--	--

1.2.	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	Арьсны өвчин судлалын үндэсний төвийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 06 сарын 17-ны өдрийн 06/20 дугаар “Эмнэлгийн бүтэц, орон тоог батлах тухай” тогтоолоор батлагдсан төвийн бүтэц орон тооны схемийг https://derma.gov.mn/files/1670920199_6398380713485.pdf-д цахим хуудсандаа байршуулсан. Иргэд, үйлчлүүлэгчдэд зориулан лавлагаа, үйлчилгээний 70135036 утсыг тогтмол ажиллуулж, нийслэлийн болон орон нутгийн иргэдэд үзлэгийн цаг олгож байна. 2024 онд нийт 69763 үйлчлүүлэгч амбулаториор болон утсаар үйлчилгээ авсан байна. Байгууллагын цахим хуудас болох https://derma.gov.mn/contact-д байгууллагын хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг зэргийг ил тод, нээлттэй байршуулсан. Мөн байгууллагын цахим хуудасны санал, гомдол цэс рүү хандалт хийж санал, хүсэлт, гомдлыг үйлчлүүлэгчдээс онлайнаар хүлээн авах боломжийг бий болгосон. Тухайн онд цахим хуудсанд https://derma.gov.mn/feedback иргэд, үйлчлүүлэгчээс 52 санал, хүсэлт, гомдлыг ирүүлснийг холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлж шийдвэрлүүлсэн.	
1.3.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Ханган нийлүүлэх байгууллагуудтай хийж байгаа бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай гэрээнүүдийг хавсралтаар баталгаажуулан гэрээний хамрах хугацааг тайлант жилд нь багтаан хийсэн. Гүйцэтгэлд нь тавих хяналтыг сайжруулах, төлөвлөлтийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн хийж, холбогдох журмыг боловсруулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах, дотоод аудитыг сонгон шалгаруулж үр дүнтэй ажиллуулах, тасаг албадуудын эм эмнэлгийн хэрэгслийн жилийн хэрэгцээ шаардлагыг бодит нөхцөл байдалтай уялдуулан тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж байх гэсэн 2 зөвлөмж 2 албан шаардлага өгснийг арилгаж, зөрчлийн биелэлтийг аудитын үндэсний газар хүргүүлсэн.	

1.4.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг Эрүүл мэндийн яам руу хагас болон бүтэн жилээр гарган хүргүүлж хяналт үнэлгээ хийлгэж байна. Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагуу арьс, харшлын төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг бүрэн хэрэгжүүлж, зардлыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасны дагуу тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу эмч, эмнэлгийн ажилчдын хооронд хөдөлмөрийн харилцааг оновчтой үр ашигтай зохион байгуулж, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэх, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийн сахилга батыг бэхжүүлэх зэрэг харилцааг хэрэгжүүлж ажиллаж байна. Статистикийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвд сар бүр хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн мэдээг 20 үзүүлэлтээр мөн халдварт өвчний өвчлөл, нас баралтын мэдээг 4	
		үзүүлэлтээр тус бүр гарган тайлагнадаг. Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу зардлыг бууруулан төсвийг үр ашигтай зарцуулж байна. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай хуулийн хүрээнд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх өдрийн хүрээнд манай байгууллага идэвхтэй оролцсон. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж сар бүр санхүүгийн мэдээ тайланг шилэн дансанд байршуулдаг. Эрүүл ахуйн хуулийн хүрээнд МС-ын а/505 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг энгийн болон аюултай хог хаягдлаар ангилан ялгалт хийж, тэмдэг тэмдэглэгээг байршуулж зөв ангилан ялгаж байна.	

1.5.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050 болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулж 2024 оны байгууллагын хөгжлийн бодлого төлөвлөлтийг 7 зорилтын хүрээнд нийт 42 ажил төлөвлөснөөс хэрэгжилт 94.7 хувьтай байна. Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийн хэрэгжилтийн тайланг ЭМС-ын 2022 оны А/346 тоот тушаалын дагуу хугацаанд нь ЭМЯ-руу хүргүүлсэн	
1.6.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Засгийн газрын тогтоолууд, 2 сайдын хамтарсан тушаалууд, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгавруудыг үйл ажиллагаандаа дагаж мөрддөг. Байгууллагын цахим хуудасны “Хууль эрх зүй” цэсэд Монгол Улсын Хууль 13, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол 4, Эрүүл мэндийн сайдын тушаал 32, байгууллагын Гүйцэтгэх захирлын тушаал 31-ыг тус тус иргэд, үйлчлүүлэгчдэд ил тод, нээлттэй харагдахаар байршуулсан.	
1.7.	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар	Захиргааны ажилчдын овог нэр, албан тушаал, харилцах утасны дугаар, майл хаяг, өрөөний дугаарыг иргэд, үйлчлүүлэгчдэд ил тод байршуулсан. Мөн хүний нөөцийн албаны даргын баталсан “Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал, иргэдийг хүлээн авах цагийн хуваар”-ийг байгууллагын цахим хуудас болон ил тод байдлын мэдээллийн самбарт тухай бүрд шинэчлэн байршуулдаг.	

1.8.	Өргөдөл, шийдвэрлэлтийн мэдээ	гомдлын тайлан, Иргэний өргөдөл, гомдлыг аман, биечлэн, утсаар, цахимаар, 11-11, бичгээр, санал хүсэлтийн дэвтрээр хүлээн авч бүртгэн, хариу арга хэмжээ авч шийдвэрлэн ажилладаг. Улирал бүр иргэний өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн тайланг ЭМХТ хүргүүлдэг. 2024 оны эхний 11 сарын байдлаар нийт 52 буюу санал, хүсэлт - 1, өргөдөл, гомдол – 49 , талархал - 1 хүлээн авч, өргөдөл, гомдлыг 100% шийдвэрлэн ажилласан.	
1.9.	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	2024 онд амбулаторийн нийт үзлэг 85989 үйлчлүүлэгч байгаагаас эмчилгээний гоо сайхны тасгийн үзлэг 12149 үйлчлүүлэгч байна. Төвий хэмжээд 4478 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлснээс 1-р тасаг 1446 2-р тасаг 1555 хүн, 3-р тасаг 140 хүн ЭЭТ 2 хүүхдийн тасаг 1335 хүн байна. ЭЭТ-т хэвтүүлсэн хүний тоо 48 тасаг дотор шилжсэн 46 гарсан 2 хүн байна. Дундаж ор хоног 7,6 Нийт үзлэг 2022 онд 43,9%-р, 2023 онд 1,9 хувиар тус тус өссөн байна. Үүнээс амбулаторийн үзлэг өмнөх онтой харьцуулахад 2022 онд 44,9%-р өссөн бол 2023 онд өмнөх оноос 2,1%-р буурсан байна. ЭГЗНС-н үзлэг өмнөх онтой харьцуулахад 2022 онд 38,7%-р, 2023 онд 25,7 хувиар тус тус өссөн байна. Яаралтай тусламжаар 2021 онд 2925 хүн, 2022 онд 4094 хүн, 2023 онд 4597 хүн, 2024 оны 10 сарын байдлаар 3298 хүн нийт 14914 хүн тусламж үйлчилгээ авсан байна. Клиник хими 12 хувь, гематологи 24 хувь, иммунологи 20 хувь, серологи 9 хувь, мөөгөнцөр 7 хувь, бактерлоги 9 хувь, демодекс 2 хувь, эдийн шинжилгээ 1 хувь, биохими 16 хувь, панел 1 хувь байна. Шинжилгээний тоо өмнөх онтой харьцуулахад 2022 онд 60 хувиар, 2023 онд 18 хувиар тус төс өссөн үзүүлэлттэй байна. Нийт шинжилгээний 12 хувийг ЦЕШ, 8 хувийг ШЕШ, 6 хувийг бактерлогийн шинжилгээ, 4 хувийг мөөгөнцрийн шинжилгээ, 1 хувийг панел, 6 хувийг серологийн шинжилгээ, 1 хувийг гистлогийн шинжилгээ, 10 хувийг биохимийн шинжилгээ, 1 хувийг СОЭ-н шинжилгээ эзэлж байна.	
1.10.	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	2024 онд дараах чиглэлээр аян болон бусад арга хэмжээнүүдийг зохион байгуулсан: 1.“Малчдад туслах сайн үйлсийн” аян”-д нэгдэх уриалгыг ажилчид	

		дунд явуулж аянд нэгдэж ажилсан. 2. 2024 оны 05-р сарын 22-ны өдөр Эрүүл Мэндийн Яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв болон Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын хамтарсан "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил 2024" өдөрлөгт идэвхтэй оролцсон. Тус өдөрлөгийн хүрээнд АӨСҮТ-ийн харшлын их эмч С.Байгалмаа иргэдэд үзлэг, зөвлөгөө өгч НЭМА-тан Х.Хэрлэн иргэдэд арьсны өвчлөлөөс урьдчилан сэргийлэх 12 төрлийн мэдээллийг 81 хүнд мэдээлэл хүргэж 74ш мэдээлэл сурталчилгааны материал тараасан байна. 3. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй соён гэгээрүүлэх аяны хүрээнд АТГ-аас гаргаж буй аяны урилгаар байгууллагын профайл болон ковер зургаа шинэчилж, аянтай холбоотой АТГ-аас гаргасан мэдээ мэдээллийг байгууллагын пэйж хуудсаар дамжуулан иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэж аянд нэгдсэн. 4. Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол дах Суурин төлөөлөгчийн газар болон эрүүл мэндийн бусад байгууллагууд хамтран олон нийтэд зориулсан “Дэлхийн тамхигүй өдөр”-ийн үйл ажиллагааг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 5-р сарын 31-ний өдөр зохион байгуулагдаж тус аянд АӨСҮТ нэгдэж оролцсон. 5. 2024.06.18 нд АШУҮИС-ийн ЭКО танхимд “ХӨДӨЛМӨРИЙН ЯАРМАГ” зохион байгуулагдсан. Өдөрлөгөөр байгууллагын танилцуулга болон ажилд орох сонирхолтой оюутнуудад мэдээлэл хүргэж, 2 төрлийн 45ш гарын авлага тарааж ажилсан. 6. “Эрүүл идэвхтэй амьдрал өдөрлөгийг” Геронтологийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран 2024 оны 10 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулсан.Тус өдөрлөгт Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлал, хүнсний аюулгүй байдлын албанаас Настаны хоол тэжээлийн онцлог, Хүнсний харшил, харшил үүсгэгч хүнс, Хоол хүнсээр дамжих өвчнөөс сэргийлэх, хүнсний бүтээгдэхүүний шошго унших, Чихрийн шижин өвчний үеийн	
--	--	--	--

	хооллолт, Геронтологийн үндэсний төвөөс Настны цогц тусламж үйлчилгээний IQ тестээр үнэлгээ хийж, Арьсны өвчин судлалын үндэсний төвөөс Арьс, харшлын эмчийн үзлэг зөвлөгөөг нийт 65 хүнд өгч ажиллаа. 7.“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ-2024” үзэсгэлэнд 2024 оны 10 дугаар сарын 4,5,6-нд “Мишээл экспо”-д 3 өдрийн турш зохион байгуулагдсан. Манай төв нь эмнэлэгтээ нэвтрүүлсэн шинэ технологиудыг танилцуулсан. Үүнд: Үс шилжүүлэн суулгах ажилбар, хайрст үлд, чонон хөрвөс, цэврүүтэх өвчний үед хэрэглэх бай эмчилгээ, харшлын эмчилгээ, гоо заслын тасагт шинээр нэвтэрсэн эмчилгээнүүдийг онцлон танилцуулж мөн арьс харшлын өвчлөлийн гарын авлага, материал тарааж ажилсан. 8.MRSA-гийн халдвараас сэргийлэх аяны хүрээнд амбулаториор үйлчлүүлж буй болон хэвтэн эмчлүүлж буй иргэдэд MRSA гэж юу вэ?, халдварлах зам, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар иргэдэд мэдээлэл хүргэж мөн хэвтэн эмчлүүлэгч тасгийн эрхлэгч нарт гарын авлага, материал тарааж мэдээлэл хүргэсэн. 9. 2024.11.06 нд MRSA-гийн халдвараас сэргийлэх аяны хүрээнд АӨСҮТ-ийн лабораторийн их эмч Б. Сүхболд MRSA-гийн халдвар гэж юу вэ? халдварлах зам, хэрхэн сэргийлэх, талаар сургалт явуулсан. Сургалтад сувилагч болон тусгай дунд мэргэжлийн нийт 18 ажилтан хамрагдлаа. Мөн MRSA нь өвчлөлөөс сэргийлэх гарын авлага болон MRSA нь эерэг гарсан ажилчдад MRSA нь тос тарааж ажилсан. 10. Хайрст үлдийн халдвараас сэргийлэх өдөрлөгийн хүрээнд амбулаториор үйлчлүүлж буй болон хэвтэн эмчлүүлж буй иргэдэд Хайрст үлд гэж юу вэ?, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар иргэдэд мэдээлэл хүргэж мөн хэвтэн эмчлүүлэгч тасгийн эрхлэгч нарт гарын авлага, материал тарааж мэдээлэл хүргэсэн.	
Хэсгийн дундаж хувь:		100
Хоёр. Хүний нөөцийн ил тод, нээлттэй байдал		

2.1.	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	Арьсны өвчин судлалын үндэсний төвийн албан ёсны сайт derma.gov.mn болон zangia.mn сайтад сул болон эзгүй орон тооны сонгон шалгаруулалтын зарыг тогтмол тавин ажиллаж derma.gov.mn -ээр 11 нээлттэй ажлын байрны зарыг оруулж, zangia.mn -ээр 57 сонгон шалгаруулалтын материал хүлээн авсан байна.	
2.2.	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	2018 оны 01 дүгээр сарын 20-ны А/96 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу шинээр ажилд орохоор ирж буй хүмүүсийг сонгон шалгаруулж авч байна. Сонгон шалгаруулалтад орж байгаа хүний материалыг хүлээн авч, сонгон шалгаруулалт явуулах хугацааг товлож, иргэнд мэдэгдэж, шалгаруулалтыг тогтсон журмын дагуу явуулж 2024 онд 34 шинэ ажилтныг томилон ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сард шинэ ажилтныг сонгон шалгаруулж, чиглүүлэн сургах журмыг шинэчлэн батлуулсан. 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Эмнэлгийн захирал болон зохион байгуулалтын нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулах журам”-ын дагуу гадаад болон дотоод хүний нөөцөөс 6 албаны даргыг сул болон эзгүй албаны даргын орон тоонд томилон ажиллаж байна.	
2.3.	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	derma.gov.mn дээр нээлттэй байршуулсан эрүүл мэндийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/256 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт дахь “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дүрэм”-ийн дагуу төвийн ёс зүйн салбар хороо тогтмол үйл ажиллагаа явуулсан. 2024 оны 02 дугаар сарын 19-ний 5 дугаар тогтоолын дагуу 10 дугаар сарын 29-ний өдрийн Захирлын тушаалаар төвийн “Ёс зүйн дэд хороо”-г байгуулан, “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг шинэчлэн батлуулсан.	

2.4.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	Байгууллагын стратегийн хүрээнд хүний нөөцийн хүний нөөцийг хөгжүүлэх, ажилтныг ур чадваржуулах, байгууллагыг чадварлаг хүний нөөцөөр хангах, ажилтны сэтгэл ханамж, нийгмийн баталгааны дэмжлэг, ажлын гүйцэтгэлийг сайжруулах зэрэг үйл ажиллагааны хэрэгжилтийг дараах хууль, тогтоол, журам, дүрмүүдийн дагуу хянаж үнэлэн ажилладаг. Үүнд: - Хөдөлмөрийн тухай хууль - Төрийн албаны тухай хууль - Засгийн газрын 240, 241, 128, 382, 395 дугаар гэх зэрэг тогтоолууд - Эрүүл мэндийн тухай хууль - Байгууллагын дүрэм, дотоод журам - Ёс зүйн хорооны ажиллах журам - Дотоод хяналтын журам - Удирдлагын баг ажиллуулах журам - Эмнэлгийн захирал болон зохион байгуулалтын удирдлага сонгон шалгаруулах журам - Шинэ ажилтныг сонгон шалгаруулах, чиглүүлэн сургах журам-ууд орно.	
2.5.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангахаар чиглэлээр хүний нөөцийн мэдээ мэдээлэл, шийдвэрийг танилцуулах, хүний нөөцийн судалгааг явуулан ажилтны сургалт хөгжил, чадварыг сайжруулах санал хүсэлтийг хүлээн авах, нээлттэй санал болгох, сул ажлын байрыг гадаад болон дотоод нөөцөөс бүрдүүлэх арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлэн ажиллаж байна.	
2.6.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	Засгийн газрын тогтоолын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу улирал тутам гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурын дагуу 1-р улиралд 105, 2-р улирал 130, 3-р улирал 133, 4-р улирал 135 эмч, сувилагч, эмнэлгийн ажилтанд урамшуулал олгосон.	
Хэсгийн дундаж хувь			100
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			

3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, 2024 оны жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг Эрүүл мэндийн яамнаас батлагдсан төсвийг АӨСҮТ-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр хуулийн хугацаанд нь батлуулан ил тод нээлттэй байдлаар шилэн дансны http://shilendans.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ болон ил тод байдлын самбарт байршуулсан.	
3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	2024 оны хагас, жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь үнэн зөвөөр зөрчилгүй Эрүүл мэндийн яаманд тайлагнасан ба шилэн дансны http://shilendans.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ ил тод, нээлттэй байршуулсан.	
3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Байгууллагын 2023 оны санхүүгийн баримтад 2023 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болгон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газрын 2024 оны 02 сарын 23-ны өдрийн 07/312 тоот албан бичгээр зөрчилгүй гэж дүгнэгдсэн.	
3.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны өдрийн 02 сарын 18-ний өдрийн 49, 50, 51 тогтоолын дагуу сонгон шалгаруулалт хийж, Кофе шоп, Эмийн сан, АТМ машин, Хүнсний автосат машин, Гадаа зогсоолыг Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн 5 гэрээ байгуулан нийт 66,625,448 мянган төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэн орлогын 40% болон 26,650,179 төгрөгийг 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар улсын төсөвт төвлөрүүлсэн.	
3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	2024 онд Цалин хөлс, нэмэгдэл урамшил төлөвлөгөөнөөс 707,646,969 төгрөг буюу -17,6%, байр ашиглалтай холбоотой зардал 18,688,496 төгрөг буюу -11,2%, нормын хувцас, зөөлөн эдлэл 1,742,370 төгрөг буюу -14%, тавилга 10,378,200 төгрөг буюу -86,5%, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 9,180,000 төгрөг буюу -95,6%, хэмнэлттэй ажилласан байна. Мөн шилэн дансны http://shilendans.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас болох https://derma.gov.mn/ -д ил тод, нээлттэй байршуулсан. Хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүгийн сахилга батыг мөрдүүлж ил тод байдлыг хангаж, үр ашгийг нэмэгдүүлж ажилласан.	

3.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр,	2024 оны 4 дугаар улирлын байдлаар Таван сая ба түүнээс дээш үнийн дүнтэй нийт 718,389,911 төгрөгийн үнийн дүн бүхий давхардсан тоогоор 169 бараа, ажил үйлчилгээ худалдан авсан. Үүнд:	
	санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	- Хүнсний материал 206,929,142 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн. - Элемент ХХК-аас 13,432,000.00 төгрөгийн Эмнэлгийн хог хаягдал тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах, аюулгүй болгох үйлчилгээ, эм ханган нийлүүлэгч компаниудаас нийт 662,336,766 төгрөгийн Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авалтыг хийсэн байна.	
3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	2023 оны 12 дугаар сарын байдлаар нийт цалингийн зардлаас бусад таван сая түүнээс дээш төгрөгийн нийт 149 ширхэг орлого зарлагын гүйлгээ хийгдсэн. Үүнд: - Үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор Эрүүл мэндийн даатгалын сан, Эрүүл мэндийн хөгжлийн төв, байгууллагын үйл ажиллагааны орлого зэргээс бүрдсэн 46 удаагийн нийт 4,698,999,229.00 төгрөгийн орлого. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор Эм эмнэлгийн хэрэгслийн зарлагын гүйлгээ /Монгол эм импекс концерн, Монбио фарм, Монфа трейд, Грийн гэйт, Дулаанхайрхан, Азифарм, Тавин ус,Монос трейд, Еврофарм, Пролианс, Ньюрфмеди, ЭНТО, Энхийн шүүдэр,Сүвэн уул, Мөнхийн тун, Нахиа импекс...гэх мэт/, Хүнсний материалын, бусад урсгал зардлын нийт 103 гүйлгээ гарч нийт 1,080,881,435.23 төгрөгийн зарлага гарсан байна.	
3.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр байхгүй болно.	

3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	2024 оны 12-р сарын байдлаар 152 ширхэг мэдээллийг үнэн бодитоор нь хуулийн хугацаанд нь хугацаа хоцролгүй шилэн дансны https://gap.mof.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ ил тод, нээлттэй байршуулан ажиллаж байна.	
3.10.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх тов мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллага боловсруулж Гүйцэтгэх захирлаар батлуулан батлагдсан төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд нийт эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж техник хэрэгсэл, хоол хүнсний материал худалдан авах 5 удаагийн тендерт Үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хороо нь босго үнийн дагуу жишиг баримт бичгийг баримтлан тендерийн баримт бичгийг боловсруулан батлуулж худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж үнийн саналын нээлтийг хийж үнэлгээг хийн захиалагчид зөвлөмж хүргүүлэн ажилласан. Тендерийн урилгыг http://tender.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас өдөр тутмын “Өдрийн мэдээ” сонинд нийтэлж тендерт оролцогч нарт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг албан бичгээр болон төрийн худалдан авалтын http://tender.gov.mn/ сайтад үнэлгээний хорооны нарийн бичиг тухай бүрд нь нийтлэн ажиллаж байна.	
3.11.	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт	2024 онд худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалт байхгүй болно.	
3.12.	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	Тендерийн үнэлгээний хорооны 5 гишүүн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох АЗ гэрчилгээний сургалтад бүрэн хамрагдан мэргэжил, арга зүйн, зөвлөгөө, зааварчилгаагаар бүрэн хангагдсан. 2024 онд АЗ сургалт байхгүй.	

3.13.	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	2024 оны санхүүгийн жилд төсвийн хөрөнгө болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй болно.	
3.14.	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил байхгүй.	
3.15.	Хууль тогтоомжид заасан бусад	Хууль тогтоомжид заагдсан бусад мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөвөөр байдлаар шилэн дансны http://shilendans.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ ил тод, нээлттэй байршуулан ажиллаж байна.	
Хэсгийн дундаж хувь			100
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл			
4.1.	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	Гүйцэтгэх захирлын 2022 оны 05 сарын 25-ны өдрийн А/30 тоот тушаалаар “Төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, үнэ, тариф”-ийг баталсан ба байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ байршуулсан. Мөн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ, амбулаторийн үзлэг, хяналт, эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ, яаралтай тусламж, үйлчилгээ, телемедицин, өдрийн эмчилгээ, үйлчилгээ, өдрийн мэс засал, сэргээн засах тусламж, үйлчилгээнүүдийг ЭМДҮЗ-ийн 2022 оны 1 сарын 28-ны “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 01-р тогтоол, ЭМДЕГДаргын 2022 оны 4 сарын 5-ны “Жагсаалт батлах тухай” А/53 тоот тушаал, Сангийн сайд Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 02 сарын 28-ны өдрийн “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” 49/А118 тоот тушаалуудын дагуу ЭМДаар үзүүлж байна.	

4.2.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх	АӨСҮТ нь 2022 оны 03 сарын 30-нд тусгай мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Эрүүл мэндийн яам 5 жилийн хугацаатай сунгуулсан. Мөн 2021 оны 01 сарын 13-нд Хэнтий аймгаас рашаан сувиллын үйл ажиллагааны чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай сунгуулсан.	
	мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа		
Хэсгийн дундаж хувь			100
Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			

5.1.	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төрөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг Үйлдвэрчний эвлэлийн хорооны болон төвийн нийт ажилчдын саналыг тусгаж 2022 оны 12 дугаар сарын 1-ны өдөр баталж мөрдөж ажиллаж байна. Хөдөлмөрийн дотоод журмаар тус төвд бүх төрлийн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд, бусад ажилтны хөдөлмөрлөх үйл ажиллагаа хамрагдан зохицуулагдаж байна. Хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах харилцаа: - Хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт, бүтцийн схем - Байгууллагын дотоод үйл ажиллагаа - Байгууллагын төлөвлөгөө тайлан, түүнд тавих хяналтын тогтолцоо - Хэтийн зорилго, эрхэм зорилго, зорилт, эрхэмлэх үнэт зүйл - Дотоод ажлын зохион байгуулалт - Дотоодын хяналт шалгалт - Өмч хөрөнгө хадгалалт, хамгаалалт, ашиглалт - Байгууллагын нууцыг тогтоох, хамгаалах - Ажил амралтын цагийн горим - Цалин хөлс, хөнгөлөлт, хангамж, урамшуулал - Чөлөө, томилолт - Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа - Хөдөлмөрийн сахилга, эд хөрөнгийн хариуцлага - Хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох, цуцлах	
5.2.	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	Дараах оюуны өмчийн эрхийг эзэмшиж байна: 1. Монгол улсын зохиогчийн эрхийн гэрчилгээ №2007/173- Вудын лампыг арьс судлалын практикт хэрэглэх нь	


		2. Нүүрс хүчлийн хийн лазер эмчилгээ №2010 3. Монгол улсын шинэ бүтээлийн патент-Биобэлдмэлийн шинжлэх ухаан, үйлдвэр худалдааны монсерум ххк-д 4. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ- бүртгэлийн дугаар: L20191023Bi01554 Оношлуурын нэр: хуурамч таван дохиурт бургасын харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил 5. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ - бүртгэлийн дугаар: L20191023Bi01555 Оношлуурын нэр: Хавтаг навчит хусны харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил 6. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ - бүртгэлийн дугаар: L20191023Bi01553, Оношлуурын нэр: Соргүй согооврын харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил 7. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01556 Оношлуурын нэр: Лавар навчит улиасын харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил 8. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01551, Оношлуурын нэр: Нугын биелэгийн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил 9. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01552, Оношлуурын нэр: Саман ерхөгийн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил 10. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01547. Оношлуурын нэр: Сиверсийн шарилжийн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил 100 11. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01548. Оношлуурын нэр: ээрэм шарилжийн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил 12. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01549. Оношлуурын нэр: цагаан луулийн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил 13. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01550. Оношлуурын нэр: ахар сорт арвайн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил	
5.3.	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт,	Хамааралгүй	

	түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл		
5.4.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төв нь Нийслэлийн засаг даргын захирамжаар 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/824 тоот шийдвэрээр нэгж талбарын 1461601580 дугаар, гэрчилгээний дугаар 0000106010, гэрээний дугаар 01119-2021/04226, бүхий 6606м.кв газрыг Төрийн захиргааны байгууллага зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшиж, эрхийн бүртгэлийн Э-2203015331 дугаартай гэрчилгээг авсан.	
5.5.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ байхгүй болно.	
5.6.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн	АӨСҮТ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн танилцуулга, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны мэдээллийг өөрчлөх бүрд шинэчлэн байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ байршуулдаг. ЭМСайдын 2020 оны 01 сарын А/52 тоот тушаалаар АӨСҮТ-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг батламжилсан. Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7-д зааснаар өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүн, хамт олныг төлөөлөх гурван гишүүн, олон нийтийг төлөөлөх гурван гишүүдээс бүрдсэн бөгөөд эмнэлгийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. • Өмчлөгчийг төлөөлөх гишүүд Л.Мөнхцэцэг, (ЭМЯ-ны СЭЗГ-н Санхүү даатгалын хэлтсийн дарга, 2023 оны 10-р сарын 30-ны А/52 тушаалаар 6 жилийн хугацаатай батламжилсан) Н.Оюун-Эрдэнэ, (СЯ, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, ЭМС-н 2020 оны 01-р сарын 31-ны	

	этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл	А/52тушаалаар 6 жилийн хугацаатай батламжилсан) Б.Баярболд, (ЭМДЕГ-н Тусламж, үйлчилгээний багц, зохицуулалтын хэлтсийн дарга, ЭМС-н А/217 тушаалаар 6 жилийн хугацаатай батламжилсан) - Олон нийтийг төлөөлөх гишүүд Б.Батцогт, (Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга, ЭМС-н 2020 оны 01-р сарын 31-ны А/52тушаалаар 6 жилийн хугацаатай батламжилсан) Ч.Отгонбаяр, (Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, АУ-ны доктор, профессор, ЭМС-н 2023 оны 10-р сарын 20-ны А/372 дугаар тушаалаар 6 жилийн хугацаатай батламжилсан) Я.Энхтөр, (АШУҮИС, АУС-ийн захирал, ЭМС-н 2023 оны 10-р сарын 20-ны А/372 дугаар тушаалаар 6 жилийн хугацаатай батламжилсан) - Хамт олныг төлөөлөх гишүүд Т.Ёндондаш, (АӨСҮТөвийн эмч, ЭМС-н 2021 оны 12-р сарын 27-ны Б/62тушаалаар 6 жилийн хугацаатай батламжилсан) Ч.Цэрэннадмид, (АӨСҮТөвийн, эмчилгээний гоо заслын тасгийн сувилагч, ЭМС-н 2020 оны 01-р сарын 31-ны А/52тушаалаар 6 жилийн хугацаатай батламжилсан) Ю.Болормаа, (АӨСҮТөвийн, хоол үйлчилгээний тасгийн эрхлэгч, ЭМС-н 2023 оны 10-р сарын 20-ны А/372 дугаар тушаалаар 6 жилийн хугацаатай батламжилсан) Н.Нарантунгалаг, (2020 оны 07 сарын 16-ны өдрөөс нарийн бичгийн даргаар томилогдсон.) ТУЗ- ийн 2020 оны 06 сарын 17-ны өдрийн 08/20 тоот тогтоолоор эмнэлгийн гүйцэтгэх захирлаар Ц.Уранчимэгийг 5 жилийн хугацаатайгаар томилсон. 2023 оны 10 сарын 30-ны өдрийн хуралдаанаар ТУЗ-ийн шинэ гишүүдийн танилцуулга явагдаж Л.Энхсайхан нь өөрийн эрхэлж байсан албан тушаалаас чөлөөлөгдсөн тул төвийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар Н.Оюунэрдэнэ, Т.Ёндондаш гишүүдийн бүрэлдэхүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох комисс байгуулж, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6. дах хэсгийг үндэслэн ТУЗ-ийн даргыг нууц санал хураалт, олонхийн саналаар ТУЗ-ийн даргаар ЭМЯ-ны Санхүү даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг сонгогдсон.	
--	---	---	--

5.7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 49, 50, 51 дүгээр тогтоолын дагуу сонгон шалгаруулалт зарлан шинээр 2 гэрээ байгуулан 2024 онд нийт 5 гэрээ байгуулан 66,625,448 төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэн ТӨБЗГ- т 40% болох 26,650,179 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.	
5.8.	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа	Хамааралгүй	

	нөлөөллийн талаарх мэдээлэл		
5.9.	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт	Лабораторийн тасгийн засарыг батлан хамгаалах яамны барилга хөгжлийн газрын 7 мэргэжилтэн хүлээн авсан.	
5.10.	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ	Хамааралгүй	
5.11.	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл	Тухайн байгууллагын эрх үүргийн дагуу эрх тавьж өгдөг бөгөөд нээлттэй мэдээллийн сангийн өргөдөл гэж байхгүй.	

5.12.	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	Байгууллагаас санхүүжүүлсэн сургалтууд: 1. 2024.04.16-ний өдөр СА-ны урилгаар ОХУ-ын Анагаахын шинжлэх ухааны доктор Г.Н.Габричевскийн нэрэмжит Эпидемиологи, микробиологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Мачарадзе Дали Шотаевна “Хүнсний харшлын эмнэлзүй, оношилгоо эмчилгээ, урьдчилан сэргийлэлт” сэдвээр цахимаар сургалт зохионы байгуулагдсан. АӨСҮТ-ийн нийт эмч нар болон резидент эмч нар бүрэн хамрагдсан.  2. 2024.09.16 нд Профессор Эгамберди Хусанович Эшбоев “Хамууны хачигны оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт” сэдвээр АӨСҮТ эмч нар болон резидент эмч нарт сургалт орсон.  3. 2024.09.16 нд профессор Ки бом су “Атопийн дерматит” сэдвээр АӨСҮТ эмч нар болон резидент эмч нарт сургалт орсон.	
--------------	--	--	--



4. 2024.06.13 нд “Эмч,эмнэлгийн мэргэжилтний эрх, ёс зүйн шинэ ойлголт” сэдэвт 1 багц цагийн сургалтыг Нарны шаргал тусгал ТББ-тай хамтран зохион байгуулсан.Сургалтанд нийт эмч, сувилагч, резидент эмч нар хамрагдсан.



Гадаадад улсад мэргэжлийн чиглэлээр богино, дунд хугацааны сургалтанд хамрагдалт:

1. 2024.01.04-18 ны хооронд 14 хоногийн хугацаатай, лабораторийн тасгийн эмч Д.Дэлгэрзаяа эмч БНХАУ-н Бээжингийн Их сургуулийн Өвөр Монголын салбар хавдрын эмнэлэгийн эмгэг судлалын тасагт төрийн санхүүжилтээр суралцсан.
2. 2024.01 сард 14 хоногийн хугацаанд, дотор, харшил судлалын эмч АУ-ны доктор С.Байгалмаа, ургамал судлаач П.Минжбадрах нар Дорно дахины Сибирийн их сургуульд ургамлын харшил судлалын чиглэлээр ажлын байрны дагалдан сургалтанд хамрагдсан.
3. ЭМЯ-ны аас зохион байгуулсан Харвардын Их Сургуулийн Зүүн өмнөд Азийн бүсийн тэтгэлэгт хөтөлбөрт, төвийн ЭМТҮЧАБА-ны дарга Ж.Булган 2023.02.27-29 хооронд 1 жилийн хугацаатай хамрагдан Эрүүл мэндийн менежментийн чиглэлээр мэргэжил

		дээшлүүлсэн. 4. 2024.04.09-.2024.05.09 хооронд 1 сарын хугацаатай, клиникийн 2-р тасгийн эхрлэгч эмч Ж.Аззаяа, ЭЭЯТТ-ийн эрхлэгч эмч Д.Чанцалдулам эмч нар хамтын гэрээний дагуу Тайван улсын Цэргийн төв эмнэлэгт мэргэжил дээшлүүлсэн. 5. 2024.10.05-2025.01.03 хүртэл лабораторийн тасгийн их Э.Дэлгэрзаяа Тайван улсад 3 сарын хугацаатай мэргэжил дээшлүүлхээр суралцаж байна 6. 2024.01.28-2024.02.03 ЭМТҮЧАБА-ны эрсдлийн менежер У. Саруул Австри улсын Зальцбург хотод Австри Америкийн сангийн дэргэдэх Open medical institute-ийн 2024 оны Арьс судлалын семинарт тэтгэлэгээр суралцсан. Сургалтын бичгийн зардал: 1,697,600	
--	--	---	--

5.13.	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	2022 оны 5 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн хүрээнд иргэдэд мэдээллийг ил тод нээлттэй хүргэж ажиллаж байна.	Хүний нөөц
Хэсгийн дундаж хувь:			100
Хэрэгжилтийн дундаж хувь:			100

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: НЭМА Х.ХЭРЛЭН
ТАЙЛАН ХЯНАСАН: ЗАХИРАЛ Ц.УРАНЧИМЭГ